

НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**«1980-ААД ОНЫ ХЯТАД» СЭДЭВТ
ОЛОН УЛСЫН СИМПОЗИУМ**

1981 оны дөрөвдүгээр сарын 22-ноос 24-нд БНАГУ-ын Карл Маркс Штадт хотноо «80-аад оны Хятад» хэмээх сэдвээр олон улсын симпозиум болов. Энэ симпозиумд БНБАУ, БНАГУ, БНУАУ, БНПАУ, БНМАУ, ЗСБНХУ, БНСЧСУ-аас гадна хөрөнгөтөн орнуудаас ХБНГУ, Итали, АНУ, Японы олон улсын харилцааны мэргэжилтэн, хятадыг судлагч эр- дэмтэд оролцож, хятадын дотоод, гадаад байдал, нийгэм эдийн засгийн хөгжлийн тухай илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлэв. Симпозиумд тавьсан илтгэлүүд дотроос ЗХУ-ын ШУА-ийн Олон улсын ажилчны хөдөлгөөний институтын профессор В. Т. Гелбрасын «БНХАУ дахь нийгмийн зөрчил ба шинэчлэл», мөн Алс Дорнодын институтын д-р А. Г. Яковлевийн «1980- аад оны БНХАУ-ын гадаад бодлого», д-р Д. В. Петровын «БНХАУ ба Японы Ази дахь ашиг сонирхлын зөрчил, өрсөлдөөн», БНАГУ-ын Гүмбольдтын их сургуулийн Д-р Роланд Фелберийн «Маогийн дараахи үеийн хятадыг судлах арга зүйн асуудал», д-р Хелмут Петерсийн «1980-аад оны эхэн үеийн БНХАУ-ын нийгмийн асуудлууд», БНУАУ-ын Олон улсын харилцааны институтын захирал, д-р Барна Талашийн «1980-аад оны Хятадын эдийн засгийн асуудал, цаашдын төлөв» зэрэг илтгэлүүд эрдэмтдийн сонирхлыг татаж байв. Социалист орнуудын эрдэмтдийн тавьсан илтгэлүүдэд БНХАУ-д болж буй үйл явдалд гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, хятадын удирдагчдын явуулж буй нийгэм эдийн засгийн бодлогын мөн чанар, шинэчлэлт, зохицуулалтын бодлогын үнэн нүүр царайг илчлэн шүүмжлэв. Социалист орны эрдэмтэд хятадын өнөөгийн удирдагчдын гадаад бодлогын чиг шугам нь Маогийн гадаад бодлогын үргэлжлэл бөгөөд империалист харгис хүчинтэй сүлбээлдэх гэсэн оролдлого нь улам хүчтэй болж, ЗХУ болон социалист бусад орны эсрэг хандсан чиглэл нь хэвээрээ үргэлжилж байна гэдгийг цохон тэмдэглэв.

Хөрөнгөтөн орны эрдэмтдээс Баруун Германы Триерийн их сургуулийн д-р Мария Луиз Нийт «Хятад-Энэтхэгийн харилцаа», Японы Токиогийн их сургуулийн профессор Тацуми Окабе «1980-аад оны Япон-Хятадын харилцаа», Баруун Германы Мюнхений олон улсын харилцаа судлах институтын д-р Иоахим Глаубиц «Хятадаас Японы талаар явуулж буй бодлого, Ази, Номхон далайн бүс дэх түүний нөлөөлөл» зэрэг илтгэлүүдийг тавив. Эдгээрээс Японы эрдэмтэн Т. Окабегийн тавьсан илтгэл нилээд сонирхолтой болов.

Хятадын дотоод, гадаад бодлогыг судлах арга зүйн хувьд социалист ба хөрөнгөтөн орны эрдэмтдийн хооронд зарчмын ялгаа байгаа нь илтгэлүүдээс харагдаж байв. Хөрөнгөтөн орны эрдэмтдийн тавьсан илтгэлүүдэд хятадын өнөөгийн удирдагчдын их гүрний дээрэнгүй бодлогыг зөвтгөх, социализмын эсрэг гадаад бодлогын чиг шугамд нь энх тайвныг эрхэмлэх хандлага буй болж байгаа мэтээр үзүүлэх гэсэн хандлага харагдаж байв.

Симпозиум нь хятадын дотоод, гадаад бодлогод дүн шинжилгээ хийж, хятадын хөгжлийн төлөвийн талаар урьдчилсан дүгнэлт хийх гэснээрээ ач холбогдолтой болов. Нөгөө талаар социалист ба хөрөнгөтөн орны эрдэмтэд хятадын асуудлаар саналаа солилцсон нь бие биеийн байр суурь, судалгааны арга ажиллагаатай танилцахад дөхөм үзүүлэв.

Д. Чулуундаваа